



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар A/18

Эг

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон
тооны бус салбар зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолын хавсралт "Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.3, 2.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дарга:	Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын дарга
	ИТХ-ын нарийн бичгийн дарга
	Ерөнхий боловсролын сургуулийн захирал
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	Соёлын төвийн дарга
	Ойн ангийн дарга
	Эх хэлний багш
	Насан туршийн боловсролын багш
	ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтан

2. Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



232501095